

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/94/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45058,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 113

танай _____ -ны № _____ -т

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН 4 ДҮГЭЭР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ДЭЛГЭРБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн 4 дүгээр сургуулийн 2025 оны 14 дүгээр сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн 4 дүгээр сургуулийн 2025 оны 14 дүгээр сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 52,780.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Боловсрол-2032" хөтөлбөрийн хүрээнд 450,423.0 мянган төгрөгийн спорт заалны засварын ажлыг капиталжуулж, 20,000.0 мянган төгрөгийн волейболын талбай, 21,110.8 мянган төгрөгийн камер, гэрэлтүүлгийн шон болон бусад хөрөнгө, Орон нутгийн өмчийн газрын даргын 2025 оны А/24 дүгээр тушаалаар 98,115.4 мянган төгрөгийн шугам хоолойг "Дархан-Ус суваг" ОНӨХК-наас шилжүүлэн авсныг холбогдох дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

4520050140

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 2,838,218.6 мянган төгрөг болж өнгөрсөн оны гүйцэтгэлээс 22.6 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Дархан-Уул аймгийн 4 дүгээр сургуулийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 95.5 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр аймгийн Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	239,411,926.16	143,552,871.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	205,103,605.50	94,153,328.77
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	205,103,605.50	94,153,328.77
3121	Төгрөг	205,103,605.50	94,153,328.77
31211	Төрийн сангийн харилцах	205,103,605.50	94,153,328.77
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		-
335	Бусад авлага		-
3351	Байгууллагаас авах авлага		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	34,308,320.66	49,399,543.17
351	Түүхий эд материал	2,372,883.00	2,363,883.00
	Эм боох материал	2,372,883.00	2,363,883.00
354	Хангамжийн материал	31,935,437.66	47,035,660.17
3541	Бичиг хэргийн материал	40,700.00	40,700.00
3542	Аж ахуйн материал	12,143,495.66	35,726,652.57
3545	Барилгын засварын материал	211,700.00	211,700.00
3546	Хүнсний материал	1,255,460.00	326,566.00
3547	Бусад хангамжийн материал	18,284,082.00	10,730,041.60
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,153,781,887.63	8,607,972,985.09
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,153,781,887.63	8,607,972,985.09
392	Биет хөрөнгө	7,654,287,887.57	8,109,178,984.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,848,330,151.00	7,298,753,221.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(307,361,026.22)	(422,749,348.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,001,140,862.65	733,305,371.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	(546,152,674.38)	(276,206,788.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	469,858,512.08	416,753,709.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(124,612,002.52)	(69,941,356.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	308,223,927.02	430,017,268.42
39215	Хуримтлагдсан элэгдэл	(48,934,925.30)	(54,548,155.39)
39217	Ном	53,795,063.24	53,795,063.24
393	Биет бус хөрөнгө	499,494,000.06	498,794,000.10
39301	Програм хангамж	9,120,550.00	8,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,170,549.94)	(2,874,299.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	493,544,000.00	493,544,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	-
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,393,193,813.79	8,751,525,857.03

IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,393,193,813.79	8,751,525,857.03
51	Засгийн газрын хувь оролцоо	2,176,264,984.77	2,176,264,984.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,176,264,984.77	2,176,264,984.77
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	4,909,637,042.07	5,267,969,085.31
5121	Өмнөх үеийн үр дүн	4,909,637,042.07	4,909,637,042.07
5122	Тайлант үеийн үр дүн		358,332,043.24
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,307,291,786.95	1,307,291,786.95
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,393,193,813.79	8,751,525,857.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,041,746,245.00	4,300,842,503.19
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,105,645.00	712,728,613.10
120	Нийтлэг татварын бус орлого	89,105,645.00	712,728,613.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,290,300.00	6,190,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,029,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,260,800.00	6,190,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	68,815,345.00	673,496,955.39
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	33,040,857.71
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,952,640,600.00	3,588,113,890.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,834,666,600.00	3,475,147,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,834,666,600.00	3,475,147,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	117,974,000.00	112,966,790.09
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	117,974,000.00	112,966,790.09
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,192,975,720.13	3,942,510,459.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,192,975,720.13	3,942,510,459.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,192,484,842.36	3,942,510,459.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,314,146,288.98	2,838,218,620.86
210101	Үндсэн цалин	1,495,460,160.15	1,754,919,992.94
210102	Нэмэгдэл	725,780,930.93	846,876,830.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт		107,997,569.57
210104	Урамшуулал	92,905,197.90	128,424,228.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	290,930,440.14	353,587,900.00
210201	Тэтгэврийн даатгал	198,328,419.81	238,231,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	23,332,655.26	28,839,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,784,482.45	14,419,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,496,816.53	14,419,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,988,066.09	57,678,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,497,472.23	99,543,240.09
210301	Гэрэл, цахилгаан	27,548,779.03	42,165,612.61
210302	Түлш, халаалт	32,850,616.48	33,318,468.48
210303	Цэвэр, бохир ус	19,098,076.72	24,059,159.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	23,846,491.20
210401	Бичиг хэрэг	-	2,926,400.00
210404	Ном хэвлэл	-	6,848,800.80
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	14,071,290.40
210408	Бараа материал акталсны зардал	-	-
2105	Нормативт зардал	149,611,230.00	205,220,584.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	1,595,300.00
210502	Хоол, хүнс	149,611,230.00	203,625,284.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,754,650.00	11,763,000.00
210604	Урсгал засвар	21,754,650.00	11,763,000.00

2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,165,726.00	49,280,295.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,029,500.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	39,136,226.00	49,280,295.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	292,379,035.01	361,050,327.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,201,025.30	70,186,869.92
210902	Хичээл үйлдэрлэлийн дадлага хийх	21,721,970.60	14,536,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130,456,039.11	276,326,757.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	490,877.77	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	490,877.77	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал		-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	490,877.77	-
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(151,229,475.13)	358,332,043.24
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсны гарз		
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(151,229,475.13)	358,332,043.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,972,930,900.00	3,594,304,690.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,290,300.00	6,190,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,290,300.00	6,190,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,290,300.00	6,190,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,029,500.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,260,800.00	6,190,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,952,640,600.00	3,588,113,890.09
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,834,666,600.00	3,475,147,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,834,666,600.00	3,475,147,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	117,974,000.00	112,966,790.09
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	117,974,000.00	112,966,790.09
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,996,853,207.35	3,648,234,066.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,996,853,207.35	3,648,234,066.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,851,213,067.35	3,445,547,676.82
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,313,896,288.98	2,838,218,620.86
210101	Үндсэн цалин	1,495,210,160.15	1,754,919,992.94
210102	Нэмэгдэл	725,780,930.93	846,876,830.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	107,997,569.57
210104	Урамшуулал	92,905,197.90	128,424,228.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	290,930,440.14	353,587,900.00
210201	Тэтгэврийн даатгал	198,328,419.81	238,231,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	23,332,655.26	28,839,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,784,482.45	14,419,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	11,496,816.53	14,419,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	45,988,066.09	57,678,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,497,472.23	99,543,240.09
210301	Гэрэл, цахилгаан	27,548,779.03	42,165,612.61
210302	Түлш, халаалт	32,850,616.48	33,318,468.48
210303	Цэвэр, бохир ус	19,098,076.72	24,059,159.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	-
2105	Нормативт зардал	-	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	
210502	Хоол, хүнс		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,985,650.00	13,423,550.00
210604	Урсгал засвар	37,985,650.00	13,423,550.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,815,726.00	54,989,295.95
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,029,500.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	40,786,226.00	54,989,295.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,087,490.00	85,785,069.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,265,590.00	67,697,069.92
210902	Хичээл үйлдэрлэлийн дадлага хийх	25,821,900.00	18,088,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145,640,140.00	202,686,390.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	145,640,140.00	202,686,390.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	145,640,140.00	202,686,390.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	490,877.77	-
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(24,413,185.12)	(53,929,376.73)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ҮН ДҮН (5)	63,284,500.00	57,020,900.00
	Дотоод эх үүсвэрээр	63,284,500.00	57,020,900.00
223001	Бусад хөрөнгө	63,284,500.00	57,020,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(63,284,500.00)	(57,020,900.00)
145	Бусад эх үүсвэр	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(87,697,685.12)	(110,950,276.73)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	292,801,290.62	205,103,605.50
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	205,103,605.50	94,153,328.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	5,060,866,517.20	8,544,423,288.92
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			(151,229,475.13)	(151,229,475.13)
8				
9				
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	4,909,637,042.07	8,393,193,813.79
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			358,332,043.24	358,332,043.24
18				
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,176,264,984.77	1,307,291,786.95	5,267,969,085.31	8,751,525,857.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,816,470,900.00	3,705,254,966.82	(111,215,933.18)	97.1%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,816,470,900.00	3,705,254,966.82	(111,215,933.18)	97.1%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,612,645,000.00	3,445,547,676.82	(167,097,323.18)	95.4%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,907,952,200.00	2,838,218,620.86	(69,733,579.14)	97.6%
210101	Үндсэн цалин	1,975,765,700.00	1,754,919,992.94	(220,845,707.06)	88.8%
210102	Нэмэгдэл	867,407,200.00	846,876,830.18	(20,530,369.82)	97.6%
210103	Унаа хоолны хөнгөлөлт		107,997,569.57	107,997,569.57	
210104	Урамшуулал	64,779,300.00	128,424,228.17	63,644,928.17	198.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	363,493,900.00	353,587,900.00	(9,906,000.00)	97.3%
210201	Тэтгэврийн даатгал	247,175,900.00	238,231,500.00	(8,944,400.00)	96.4%
210202	Тэтгэмжийн даатгал	29,079,600.00	28,839,200.00	(240,400.00)	99.2%
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,539,700.00	14,419,500.00	(120,200.00)	99.2%
210204	Ажилгүйдлийн даатгал	14,539,700.00	14,419,500.00	(120,200.00)	99.2%
210205	Эрүүл мэндийн даатгал	58,159,000.00	57,678,200.00	(480,800.00)	99.2%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,258,000.00	99,543,240.09	(15,714,759.91)	86.4%
210301	Гэрэл, цахилгаан	46,005,000.00	42,165,612.61	(3,839,387.39)	91.7%
210302	Түлш, халаалт	44,126,500.00	33,318,468.48	(10,808,031.52)	75.5%
210303	Цэвэр, бохир ус	25,126,500.00	24,059,159.00	(1,067,341.00)	95.8%
2104	Хангамж, бараа материалын зардал			-	0.0%
2105	Нормативт зардал	-	-	-	0.0%
210502	Хоол, хүнс	-	-	-	0.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,550,000.00	13,423,550.00	(126,450.00)	99.1%
210604	Урсгал засвар	13,550,000.00	13,423,550.00	(126,450.00)	99.1%
2107	Томилолт, зочны зардал	-	-	-	0.0%
210702	Дотоод албан томилолт			-	0.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,695,800.00	54,989,295.95	(1,706,504.05)	97.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,695,800.00	54,989,295.95	(1,706,504.05)	97.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	155,695,100.00	85,785,069.92	(69,910,030.08)	55.1%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,606,900.00	67,697,069.92	(69,909,830.08)	49.2%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,088,200.00	18,088,000.00	(200.00)	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	203,825,900.00	259,707,290.00	55,881,390.00	127.4%
2132	Бусад урсгал шилжүүлэг	203,825,900.00	202,686,390.00	(1,139,510.00)	99.4%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж олгох урамшуулал	203,825,900.00	202,686,390.00		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал			-	0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох			-	0.0%
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	0.0%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		57,020,900.00	57,020,900.00	0.0%
	Дотоод эх үүсвэрээр		57,020,900.00	57,020,900.00	0.0%
223001	Бусад хөрөнгө		57,020,900.00	57,020,900.00	0.0%

1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,816,470,900.00	3,594,304,690.09	(222,166,209.91)	94.2%
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,475,147,200.00	3,475,147,100.00	(100.00)	100.0%
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,475,147,200.00	3,475,147,100.00	(100.00)	100.0%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			-	0.0%
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	128,808,000.00	112,966,790.09	(15,841,209.91)	87.7%
132001	Орон нутгийн төсвөөс	128,808,000.00	112,966,790.09	(15,841,209.91)	87.7%
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС			-	0.0%
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			-	0.0%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	212,515,700.00	6,190,800.00	(204,584,900.00)	2.9%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,740,000.00			
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,680,800.00	6,190,800.00	510,000.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	205,094,900.00		(205,094,900.00)	
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			-	0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		205,103,605.50	205,103,605.50	0.0%
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		94,153,328.77	94,153,328.77	0.0%
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	0.0%
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0%
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1	1	-	100.0%
6	Удирдах ажилтан	104.00	104.00	-	100.0%
7	Гүйцэтгэх ажилтан	1	1	-	100.0%
8	Үйлчлэх ажилтан	76	76	-	100.0%
9	Гэрээт ажилтан	27.00	27.00	-	100.0%
10	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,225.00	1,225.00	-	100.0%
14	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА				0.0%
15	Төрийн өмчит СӨБ байгууллага				0.0%
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)				

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 5,600.0 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав.
Үүнд:

- 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланд цалин хөлс тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын 5,600.0 мянган төгрөгийн өр төлбөрийг тайлагнаагүй байна. 2025 оны санхүүгийн тайланд өр төлбөр тайлагнаагүй болно.

Аудитаар нийт 7,753.7 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул төсвийг хохиролгүй болгох 600.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 3,703.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,450.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн сургалт, семинарын зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан захирал Д.Дэлгэрбаярт сургалтын төлбөрт 600.0 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 7-д “Танхимаас гадуурх хичээл сургалтын үйл ажиллагааны зардал (Сургалт семинар) буюу Танхимын бус сургалтын үйл ажиллагааны зардалд суралцагчдыг сургуулиас гадна музей, номын сан, түүхийн дурсгалт газарт түшиглэн танхимаас гадуурх сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зардал багтана.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна

5.2 Албан шаардлага

5.2.1 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн захирал Д.Дэлгэрбаяр нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,144.0 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В дэх

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг **аль нэг ажилтанд хавсран хариуцуулна**. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмээгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2.2 Илрүүлэлт: Тайлант онд тус сургуулийн нягтлан бодогч Л.Ганзоригт Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 1/3492 тоот албан бичгийг үндэслэн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар "өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул 1,559.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна гэж" заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

5.1.1. Илрүүлэлт:

Тайлант онд тус сургуулийн үндсэн хөрөнгөнд тооллого хийхэд 5 нэр төрлийн 12 ширхэг өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 3,450.7 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д заасныг баримтлан, өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж бүртгэн ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2025 оны 2-р улирлын санхүүгийн тайланд Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татварын өр төлбөрийг тайлагнаагүй байна.	1	5,600.0	1	5,600.0	-	-	1	5,600.0	-	-	-	-
Дүн	1	5,600.0	1	5,600.0	-	-	1	5,600.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		/мянган төгрөгөөр/		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн
Тайлант онд сургалт, семинар зориулалт, арга хэмжээнд төсөвлөгдсөн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан төлбөрийг захирал Д.Дэлгэрбаярт олгосон байна.	1	600.0	1	600.0								
Тайлант онд нягтлан бодогчид балансын урамшуулалыг үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон байна.	1	1,559.0			1	1,559.0						
Тайлант онд тус сургуулийн захирал Д.Дэлгэрбаяр нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс олгосон байна.	1	2,144.0			1	2,144.0						

Тайлант онд тус сургуулийн үндсэн хөрөнгөнд тооллого хийхэд 5 нэр төрлийн 12 ширхэг өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 3,450.7 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй	1	3,450.7					1	3,450.7				
Дүн	3	7,753.7	1	600.0	1	3,703.0	1	3,450.7	-	-	-	-